



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
**БИЕЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 03 сарын 29 өдөр

Дугаар 4/199

Улаанбаатар хот

Ёс зүйн дэд хороог шинэчлэн
байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.18 дахь заалт, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалт, Биеийн тамир, спортын улсын хорооны шударга байдлын үнэлгээг нэмэгдүүлэх төлөвлөгөөний 5 дахь заалт, Байгууллагын хамт олны 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын хамт олны хурлын тэмдэглэлийг үндэслэн Биеийн тамир, спортын улсын хорооны Ёс зүйн дэд хороог дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

Бүрэлдэхүүнд:

Д.Цэрэнболд
С.Мөнх-Эрдэнэ

Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
Биеийн тамир, спортын бодлого, төлөвлөлт
хариуцсан ахлах мэргэжилтэн

Б.Лхагваням

Салбарын мэдээлэл, технологийн бодлогын
зохицуулалт, аюулгүй байдал хариуцсан ахлах
мэргэжилтэн

Ш.Баясгалан

Спортын сургалт дасгалжуулалтын төлөвлөлт,
дотоод асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

С.Номин

Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, тайлан мэдээ
хариуцсан мэргэжилтэн

2. Ёс зүйн дэд хорооны гишүүдээр сонгогдсон гишүүд Ёс зүйн хорооны дэд даргыг сонгож, шийдвэрийг 2024 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн дотор Төрийн захиргааны удирдлагын газарт ирүүлэхийг даалгасугай.

3. Ёс зүйн дэд хорооны гишүүдэд байгууллага дотор гарч байгаа болон үүсэж болзошгүй ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан, нөхцөл, эрсдэлийг тооцох, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг төлөвлөн зохион байгуулж, ёс зүйн зөрчил, тайлан, мэдээг хуульд заасан хугацаанд Төрийн албаны зөвлөлийн дэргэдэх Ёс зүйн хороонд хүргүүлж ажиллахыг үүрэг болгосугай.

4. Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2023 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн А/303 дугаар "Ёс зүйн дэд хороо байгуулах тухай" тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



О.БАТТУЛГА

142410527